

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Төсөл хэрэгжүүлэгч болон төслийн товч танилцуулга	2
1.2. Төслийн талбайн байршил	3
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН БАЙДАЛ	5
2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	6
2.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	9
2.3. Дүйцүүлэн хамгаалах ажил	10
2.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10
2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	10
2.6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	10
2.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	11
2.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт.....	11
2.9. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд	11
2.10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	11
2.11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	13
ДҮГНЭЛТ	14
Хавсралт материалууд.....	15

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1.Төсөл хэрэгжүүлэгч болон төслийн товч танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч	<p>“Манлай геологи хайгуул” ХХК нь 2017 оны 04-р сарын 12-ны өдөр уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх үйл ажиллагааны чиглэлтэй үүсгэн байгуулагдсан.</p> <p>Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011669047, Регистрийн дугаар: 6172601</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 18-р хороо, 1 хороолол, 13а, 15 тоот</p>
Төслийн нэр	“Хуурай-1” алтны шороон ордын төсөл, Дугаар:2021/ОА-77
Тусгай зөвшөөрлийн дугаар	“Хааны харгуй” ХХК-д Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Хуурай-1 нэртэй газарт орших 31.71 гектар уурхайн талбайд 2016 оны 12 сарын 27-ны өдөр АМГТГ-аас MV-020732 тоот тусгай зөвшөөрлийг олгосон. 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Кадастрын хэлтсийн даргын 398 дугаар шийдвэрээр “Манлай геологи хайгуул” ХХК-д MV-021731 тусгай зөвшөөрөл болгон шилжүүлсэн.
Төслийн зорилго, ач холбогдол	Төсөл хэрэгжсэнээр нийт 64 хүний ажлын байр шинээр бий болж улсын болон орон нутгийн төсөвт нийт 1.1 тэрбум төгрөгийн татвар төлбөр, хураамжийг төвлөрүүлнэ. Уг ордыг ашиглах төсөл нь компани болон улс, тухайн орон нутагт нийгэм эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой юм.
Нөөц бүртгэх тухай тушаал, дүгнэлт	<p>Төсөлд ашиглалтын үеийн бохирдол 18.57% буюу 8.08 мян.м³ байхаар тооцож геологийн боломжтой С зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В нөөцөд шилжүүлэн тооцноор үйлдвэрлэлийн нийт элс 42.73 мян.м³ буюу 56.07 кг алт олборлохоор тооцсон байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 218.42 мян.м³ хөрс хуулалт хийхээр тооцсон.</p> <p>Жилд 15 мян.м³ элс олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 3 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн.</p> <p>Элс угаан баяжуулах цех нь жилд 15 мян.м³ элс баяжуулах хүчин чадалтай байна. Төсөл хэрэгжих 3 жилийн хугацаанд нийт 1312.17 мг/м³ /химийн цэвэр/ дундаж агуулгатай 42.73 мян.м³ элсэнд агуулагдах 56.07 кг алтыг баяжуулж, 88.4%-ийн металл авалттай 49.57 кг алт үйлдвэрлэхээр төслийн ТЭЗҮ-д тусгажээ.</p>
Эдийн засгийн тооцоолол	<p>Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 3.0 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 7.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 4.5 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 4.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 1.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгасан. Уурхайн ашиглалтын хугацаанд 1 кг алтны бүрэн өөрийн өртөг 61.76 сая.төг/кг байна.</p> <p>Төсөл хэрэгжих хугацаанд нийт 7.6 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өгөөжийн дотоод</p>

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ТАЙЛАН

	норм (IRR) 90.0% хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.3 жил байхаар тооцжээ.
Ашиглалтын технологи	<p>Ордын уул техникийн нөхцөлүүдийг харгалзан үзэж Хуурай-1 алтны шороон ордыг ил уурхайн аргаар, авто тээвэртэй ашиглалтын системээр олборлоно. Хуурай-1 алтны шороон ордын ашиглалтын нийт хугацаанд 218.42 мян.м³ хөрс хуулж, 42.73 мян.м³ элс олборлон баяжуулах бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент 5.11 м³ байна. Ашиглалтын хугацаанд уурхайгаас дунджаар 1312.17 мг/м³ агуулгатай, технологийн хаягдал тооцоод химийн цэврээр 49.57 кг алт олборлон борлуулахаар тооцоолсон байна.</p> <p>Энэ орд нь гарал үүслийн аллюви-пролювийн, байршлын хувьд харьцангуй энгийн тогтоцтой хөндийн дагуу сунаж тогтсон орд юм. Хуурай-1 алтны шороон орд нь нөөцийн ангиллын 3-р бүлэгт хамаарна.</p>


1.2.Төслийн талбайн байршил

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь засаг захиргааны хувьд Дархан-Уул аймгийн Хонгор сумын II-р багийн нутагт харъяалагдана. Эдийн засгийн хувьд энэхүү талбай нь уул уурхай олборлолтын дэд бүтцийн Шарын голын алтны шороон ордын зангилаанд хамаарна. Энд Шарын голын шороон ордууд болон Шарын голын нүүрсний уурхай ашиглагдаж байгаа бөгөөд Дархан хоттой төмөр замаар холбогдож мөн өндөр хүчдэлийн шугамаар холбогдсон. Улаанбаатар хотоос 230 км зайд (үүнээс 175 км засмал зам, 55 км сайжруулсан шороон зам), Шарын голын нүүрсний уурхай ба Шарын голын төмөр замаас 8 км зайд байрлана.

Хүснэгт 1. MV-021731 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Захын цэгийн солбилцол						Талбайн хэмжээ, га
		Уртраг			Өргөрөг			
Хуурай-1	MV-021731	106	33	55.26	49	13	10	31.71
		106	33	55.26	49	13	26.91	
		106	33	25.26	49	13	26.91	
		106	33	25.26	49	13	10	

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ТАЙЛАН



Зураг 1.1 MV-021731 тоот тусгай зөвшөөрлийн талбайн сансрын зураг

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН БАЙДАЛ

Алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2022 онд урьдчилсан байдлаар 11978.2 мян.төгрөг зарцуулахаар тусгасан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар уурхайн олборлолтын үед гарч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, нэгэнт бий болсон сөрөг үр дагаврыг бага гэлтгүй тухай бүр нь нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх бололцоотой юм.

БОМТ-г хэрэгжүүлснээр дараах зорилтууд хангагдана. Үүнд:

- Монгол улсын БОАЖЯ- наас тавьж буй байгаль орчныг нөхөн сэргээх болон сөрөг нөлөөллийг бууруулах талаар тавьж буй шаардлагыг аль болохоор хангасан байх;
- Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шат дамжлага бүрт технологийн журам зааврыг байгаль хамгаалах хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандарт шаардлагад нийцүүлэх;
- Байгаль орчны менежментийн талаар БОНБНҮ-ээр дэвшүүлсэн зорилго зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг биелүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар төслийн холбогдох ажилтнуудад зориулан товч, тодорхой зааварчилгаа өгөх;
- Байгаль орчны менежментийн арга хэмжээ, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон, удирдлагын шатлалын дараалал бий болгох;
- Төсөл хэрэгжүүлэгч буюу гэрээт гүйцэтгэгч бүр байгаль орчныг хамгаалахтай холбоотой үүрэг хариуцлагаа мэдсэн байх ба үүргээ биелүүлэхэд шаардлагатай ур чадвар, бэлтгэл сургалт, мэргэжилтэй байх;
- Байгаль орчинд гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг аль болохоор бууруулж, байгаль орчныг хамгаалж байгаль орчны тухайн төлөв байдлыг хэвийн хадгалах зорилтыг хангах үүднээс үүнд хамаарах тодорхой тогтолцоо, дэг журам, ажлын зааварчилгааг тодорхойлох;
- Тухайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг төлөвлөж явуулахад лавлах баримт бичиг болох;



2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

№	Сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	Зарцуулсан зардал /мян.төг/	Зохион байгуулж хийгдсэн ажлууд	Гарсан үр дүн
1. АГААРЫН ЧАНАР				
1	Тоосжилт, агаарын бохирдол: Уурхайн барилга байгууламж, нөхөн сэргээлтийн талбай түүний орчим тоосжилт, машин механизмаас гарах хорт хий (нүүрсхүчлийн хий, бензоприн, нүүрсустөрөгч)	530.000	<ol style="list-style-type: none"> Орчны тоосжилтийг бууруулах хамгийн энгийн арга болох олон салаа зам гаргахгүйгээр аж ахуйн дотоодын замын маршрутыг гаргаж тэмдэгжүүлэн хүнд машин механизмын операторуудад батлагдсан замналаар зорчих, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилласан. Тухайн тайлант жилийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн хугацаанд хур тунадас олон жилийн дундажаас харьцангуй их орсон нь тоосжилтыг бууруулж байсан. Нөхөн сэргээлт хийж байх хугацаандаа батлагдсан замналаар орчны тоосжилтыг бууруулах үүднээс замын суларсан хэсгийг хусч цэвэрлэх, талбайн усалгааг өдөр бүр 1 удаа тогтмол хийхээс гадна шаардлагатай үед тоосжилт үүсэж байгаа газруудыг хэсэгчлэн замын усалгааг хийж байсан. Ажилчдын хөдөлмөр хамгаалалын аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэл болох маск, бээлий, нүдний шил зэргээр бүрэн хангаж ажилласан. Монгол улсад баримталж байгаа дараах норм, дүрм, стандартыг мөрдлөг болгон ажилласан. <ul style="list-style-type: none"> ✓ Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ, техникийн ерөнхий шаардлага MNS5885:2008 ✓ Замын тэмдэг, техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2003 ✓ Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 ✓ Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 	<ol style="list-style-type: none"> Орчны агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл буурсан. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж байгаа газрын тоосжилтийг дарснаар орчны тоосжилтыг бууруулахаас гадна хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд чухал ач холбогдолтой байсан. Ажилчдын эрүүл мэндэд мөн ач холбогдолтой байсан.
2. ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ				
2	Усны нөөц багасах, бохирдох: Гол горхины орчим, усны эх үүсвэр	7.621.424	<ol style="list-style-type: none"> “Хараа-Ерөө голын сав газар”-тай ус ашиглах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулж гэрээний заалтыг мөрдөн хамтран ажилласан. 	<ol style="list-style-type: none"> Голын эрүүл аюулгүйн бүсийг цэвэрлэж далан



			<ol style="list-style-type: none"> 2. Ус ашиглах гэрээний дагуу усны төлбөрийг төлж барагдуулсан. 3. Усны тухай хуулийн 24.4-д зааснаар ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журмын дагуу ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулсан. 4. Усны эх үүсвэрийг бохирдохоос хамгаалж шороон далан бий болгосон. 5. Гол, горхи орчим 2 удаагийн цэвэрлэгээг хийж, цуглуулсан хог хаягдлыг ангилан төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэж тавьсан. 	<p>үүсгэснээр усны бохирдлыг бууруулах, нөөцийг хамгаалах</p> <ol style="list-style-type: none"> 2. Бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарласнаар усны бохирдлыг бууруулах, саарал усыг дахин ашиглах зэрэг ач холбогдолтой. 3. Гэрээнд тусгагдсан ус ашигласан төлбөр тооцоог хийснээр байгаль орчныг нөхөн сэргээх, гэрээнд тусгагдсан үүргээ биелүүлэх нөхцөл болно.
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ				
3	<p>Уурхайн нөхөн сэргээлт, тээвэрлэлтийн явцад хөрсний элэгдэл эвдрэл үүсэх, доройтох, талхлагдах, бохирдох: <i>Төслийн талбай түүний ойр орчим</i></p>	750.000	<ol style="list-style-type: none"> 1. Уурхайн хөрс хуулалт, олборлолт, аж ахуйн дотоодын тээврийн үйл ажиллагаанаас хамаарч орчны газрыг доройтохоос сэргийлэн хөрс хуулалт, олборлолт хийж байгаа орчмыг хашаажуулах, гадаргын усны урсацыг хэвийн гольдролын дагуу барих үүднээс суваг шуудуу татаж хамгаалсан. 2. Олгогдсон газарт техникийн болон явган хүний зорчих хэсгийн замыг засаж сайжруулсан. Ингэснээр зорчих хэсгийн аюулгүй байдлаас гадна олон салаа зориулалтын бус зам гаргаж хөрсний физик элэгдэл эвдрэлд орохоос сэргийлэх, тоос шороо босохгүй байх, хөрс хуулалтыг стандартын дагуу хуулах, хадгалах зэрэг процессууд норм, дүрмийн дагуу хийгдсэн. 3. Дээрх үйл ажиллагаануудын хүрээнд нийт ажиллагсад зааварчилгаа өгч тэдгээрт ИТА-ын зүгээс тогтмол хяналт тавьж хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дагуу ажилласан. 	<ol style="list-style-type: none"> 1. Хөрсний ухлага, овоолго, хөрс хуулалтын явцаас ойр орчмын газарт хөрсний элэгдэлд эвдрэлд орохоос сэргийлж, усны болон салхины элэгдлээс хамгаалсан. 2. Ажиллагсадын эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлсэн. 3. Хөрс шатах тослох материалаар бохирдох



			<ol style="list-style-type: none"> 4. Зам талбай засах ажлыг олборлолтоос гарсан хайрга, дайрга, чулууг ашигласан. 5. Норм дүрэмд заагдсны дагуу буюу овоолгыг 5 м-ээс илүүгүй байдлаар үүсгэж ус салхины нөлөөгөөр нуралтаар сэргийлэх, салхинаас хамгаалах үүднээс салхины зонхилох чиглэл дагуу байрлуулсан. 6. Машин техникийн авто зогсоол болон засвар үйлчилгээний цэгийг тусгай тэмдэглэгээтэй газарт байршуулсан. 7. Шатах тослох материал хадгалах газрыг тэмдэгжүүлэн эрсдэл гарч асгарах тохиолдолд саармагжуулах элс, модны үртэс, шлам, хүрз, жоотуу, сав зэрэг багаж хэрэгслийг байршуулсан. 8. Хөрсний ахуйн болон эрүүл ахуйн бохирдлоос сэргийлж хог хаягдлын түр цэг байршуулж, хог тээвэрлэх аж ахуйн нэгжтэй хийсэн гэрээний дагуу тээвэрлүүлж байсан. 	<p>эрсдлээс сэргийлсэн.</p> <ol style="list-style-type: none"> 4. Хөрсний эрүүл ахуйн болон ахуйн бохирдлоос урьдчилан хамгаалах арга хэмжээ авсан. 5. Үйл ажиллагаа явуулж байгаа газрыг хэсэгчлэн хашаажуулснаар хөдөлмөр хамгаалалыг хяналттай болгосон.
4. ГАЗРЫН ХЭВЛИЙ				
4.	<p>Газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох. Төслийн талбай буюу олборлолт хийж буй газарт</p>	2.736.000	<ol style="list-style-type: none"> 1. Уурхайн олборлолт явуулсан газрын унаган төрхөд ухлагын явцад өөрчлөлт орсон ба төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашигласан. 2. 2022 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу 129.838 мян.м³ олборлох байсан хэдий ч шатахууны үнийн өсөлт, хомсдол зэргээс шалтгаалан төлөвлөсөн хугацаанаас хоцорч 05 сараас гарах байсан ажил 08 сарын 02-ноос 11 сарын 06-ны хугацаанд ажиллахдаа нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн. 3. Төслийн тайлант жилд 2.17 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг Монгол улсад мөрдөгдөж байгаа “Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх техникийн ерөнхий шаардлага” MNS 5917:2008-ийн дагуу гүйцэтгэсэн. 4. 0.8 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажил 50 хувьтай хийгдсэн. 	<ol style="list-style-type: none"> 1. Олборлолтын явцад байгалийн унаган төрхөө алдаж физикийн эвдрэлд өртсөн газрыг Монгол улсад мөрдөгдөж байгаа норм дүрмийн дагуу техникийн нөхөн сэргээлтийг хийснээр унаган төрхөд нь дөхүүлэн дараагийн биологийн нөхөн сэргээлтийн ажилд бэлтгэсэн.
5. УРГАМЛАН НӨМРӨГ				
5	<p>Ургамлан нөмрөгт өөрчлөлт орох. Төслийн талбай болон</p>		<ol style="list-style-type: none"> 1. Төслийн талбайд өмнөх онд олборлолт явуулж байсан газраа үргэлжлүүлж олборлолт хийгээгүй. Мөн орчны тоосжилтыг бууруулж усалгааг тогтмол хийж, үйл ажиллагаа явуулж байгаа газраа хашаажуулж, 	<ol style="list-style-type: none"> 1. Төслийн болон орчны газрын ургамлан нөмрөгт сөрөг нөлөө

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ТАЙЛАН



	<i>орчны ургамлан нөмрөг бүхий газар</i>		хүний болон техникийн замыг хийснээр орчны ургамлан нөмрөгт өөрчлөлт ороогүй.	үзүүлээгүй ба нөхөн сэргээлт хийсэн хугацаа нь ургамлын хагдарч эхлэх цаг хугацаатай давхардаж байсан.
6. АМЬТНЫ АЙМАГ				
6	Амьтдын амьдрах орчин доройтох, хязгаарлагдах. <i>Төсөл хэрэгжүүлж буй орчин</i>	200.000	1. Хууль бус ан агнуураас урдчилан сэргийлэх, нийт ажилтан ажиллагсдыг тодорхой мэдлэг мэдээлэлтэй болгох үүднээс 1 удаа сургалт зохион байгуулсан. 2. Уурхайн нөхөн сэргээлтийн ажил хийгдснээр мал амьтан унах эрсдлээс сэргийлсэн. Амьтдын тархалт болон нүүдэллэх хөдөлгөөнд саад тотгор учруулаагүй. Ямар нэгэн зөрчил гараагүй болно.	1. Хууль бус ан агнуурын талаар мэдлэг мэдээлэлтэй болсон.
	Нийт төсөв	11.837.424		

2.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээх арга хэмжээ	2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэмжээ	Төлөвлөгөөт онд хийгдсэн ажлын хэмжээ	Стандарт, норм дүрэм, аргачлал
1	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго хийх	3.58 га	Техникийн нөхөн сэргээлтийг 3 хэсэг газар нийт 2.95 га талбайд хийснээс 2.71 га-ийн техникийн нөхөн сэргээлт буюу дотоод овоолгыг хийж хэвгийжүүлэн засах ажлыг гүйцэтгэсэн. 0.8 га талбайд дотоод овоолгын ажил 3-6 м гүн хүртэл хийгдсэн. 0.8 га талбайн нөхөн сэргээлтийг 2023 онд бүрэн хийж биологийн нөхөн сэргээлтийн ажилд бэлтгэж дуусгана.	MNS5917: 2008
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсөөр хучих, ургамалжуулах, нэг болон олон наст ургамал ургуулах	3.58 га	Техникийн нөхөн сэргээлтийн ажил бүрэн хийж дуусгасан 2.17 га газрыг шимт хөрсөөр хучиж олон настын үрийг нормын дагуу цацаж биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	MNS5918: 2008

Дээрх техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 2.736.000 төгрөг зарцуулсан болно.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ТАЙЛАН

2.3. Дүйцүүлэн хамгаалах ажил

№	Дүйцүүлэн хамгаалах зорилго	Төлөвлөсөн арга хэмжээ	Ажлын зардал
1	Аюул заналыг бууруулах арга хэмжээ	Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажлыг бусдаар гүйцэтгүүлэх	10.000.000 төгрөг

2.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

Цаашид хуулийн дагуу ажиллах ба олборлолтын ажлыг анхаарал болгоомжтой явуулах ба газрын гүнээс ямар нэгэн байдлаар археологи, палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд даруй уулын ажлыг зогсоон, зохих газруудад мэдэгдэн авран хамгаалах ажлыг холбогдох хууль журмын хүрээнд гүйцэтгэнэ.

2.6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн ерөнхий инженер 2022 оны 08 сарын 02-ны өдөр нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхээс өмнө нийт ажилтан, ажиллагсдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, гал түймрээс урдчилан сэргийлэх, болзошгүй аюулын үед авах арга хэмжээний талаар танилцуулж сургалт явуулсан.

Ажил гүйцэтгэхээс өмнө бүх хүмүүстэй хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцуулж гарын үсэг зуруулж ажилласан.

Ажилчдад эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх зорилгоор эм бэлдмэл, эмийн санг бэлтгэсэн.

Ажлын орчны цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын үзлэгийг 7 хоног бүр хийж байв.

Ажилчид нэг бүрийг хөдөлмөр хамгааллын бүрэн хувцас, хэрэглэлээр хангахаас гадна мэргэжлээс шалтгаалах онцлогоос хамааруулан хор саармагжуулах бүтээгдэхүүн болох сүү цагаан идээгээр хангасан.

Тухайн 2022 онд уурхайн үйл ажиллагааны явцад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны ямар нэгэн зөрчил гараагүй.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ТАЙЛАН

2.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлыг эх үүсвэрээс нь хамааруулан ахуйн, үйлдвэрийн, аюултай хог хаягдал гэж ангилан тусгай түр хогийн цэгийг байрлуулсан хогийн цэгт төвлөрүүлсэн.

Ахуйн хог хаягдлыг цаас, хүнсний, хуванцар, бусад гэж ангилж дахин ашиглах боломжтой, боломжгүйгээр тусгай хогийн цэгт төвлөрүүлж хуванцар сав, ундаа лаазны сав, тугалган сав зэргийг түүхий эд авах газруудад өгч бусад хог хаягдлыг хөрсний бохирдол үүсгэхгүйгээр тусгайлсан савалгаанд хуримтлуулж байсан.

Үйлдвэрийн хог хаягдлыг төмрийн, модны гэж ангилан төмрийн хог хаягдлыг 2 дагч түүхий эд авах газарт харин модны хогийг түлшинд хэрэглэв.

Аюултай хог хаягдлыг уурхайн үйл ажиллагааны явцад гарсан хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг ангилан ялган тусгай цэгт цуглуулж, төвлөрсөн цэгт тушаах, ШТМ-ын хаягдлыг хуримтлуулан хаягдал авах газарт хүргүүлж ажиллахаар төлөвлөсөн.

Дээрх хог хаягдлын цэгүүдийг тогтмол ариутгаж, 14 хоногт 1 удаа нийтийн цэвэрлэгээг зохион байгуулсан.

Нийт 580.000 төгрөгийн ажлыг хийсэн.

2.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт

Дээрх ажлын хүрээнд ямар нэгэн ажил зохион байгуулж ажиллаагүй.

2.9. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажлыг бусдаар гүйцэтгүүлэхээр БОАЖГ, Хонгор сумын Засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр тус бүр 10.000.000 төгрөгийн нийт 20.000.000 төгрөгийн хандив дэмжлэг үзүүлсэн.

2.10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцсан албан тушаалтан	Биелэлт
1	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэнг захирлын тушаалаар томилох, байгаль орчны асуудлыг хариуцан ажиллах	Удирдлага	Захирлын тушаалаар уурхайн даргыг томилж ажилласан.
2	Ашиглалтын үеийн хайгуулын ажлын төлөвлөгөөг батлуулах	Геологи инженер	Хайгуулын ажил хийгдээгүй
3	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах	Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайн дарга хариуцан ажилласан
4	Байгаль орчны менежментийн	Байгаль орчны	Мэргэжлийн байгууллагатай хамтран

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ТАЙЛАН

	төлөвлөгөөний тайланг тухайн жилийн 10 дугаар сарын 31 ны дотор Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлэх	мэргэжилтэн	ажилласан
5	Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн газрын төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улирал бүрийн эхний сарын 20-ны дотор төлөх	Удирдлага	
6	“Монгол ус” ТӨААТҮГ-аар ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах, төлбөрийг төлөх	Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайн дарга хариуцан холбогдох газар мэргэжилтэнтэй холбогдох төлбөрийг төлж дүгнэлтийг гаргуулсан.
7	Болзошгүй аюул ослын үед ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах	ИТА	Уурхайн нээлтэнд уурхайн дарга хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны болон эрсдлээс сэргийлэх, авах арга хэмжээний тухай сургалтыг зохион байгуулж ажилласан. Ажилд гарах, ажил хүлээлцэх бүрт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байсан.
8	БО-г хамгаалах, ХАБЭА, ШТМ-ын асгаралт, хадгалалт, ашиглалт, устгалын чиглэлээр өөрийн ажилтан, ажилчдын дунд улирал тутамд сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, Өдөр тутамд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	ИТА	
9	Байгаль орчныг хамгаалах мэдээ мэдээлэл, сурталчилгааны самбар хийж байнгын цахим мэдээллээр хангах	Байгаль орчны мэргэжилтэн, ИТА	Төлөвлөгөөг боловсруулсан.
10	Орон нутгийн удирдлага болон иргэдэд төслийн үйл ажиллагааны биелэлт, байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар танилцуулга, хэлэлцүүлгийг тогтмолт хийж байх	Байгаль орчны мэргэжилтэн, ИТА	Орон нутгийн удирдлага, байгаль орчны байцаагчтай холбогдож хийж буй ажлын талаар мэдээллийг солилцож хамтран ажилласан.
11	Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны аудитыг 2 жил тутамд 1 удаа хийлгэх	Удирдлага	2023 онд байгаль орчны аудит хийгдэхээр төлөвлөгөөндөө тусгасан.
12	Төслийн үйл ажиллагааны явцад газрын төлөв байдал чанарын хянан баталгааг 5 жил тутамд 1 удаа хийлгэх	Удирдлага	Мэргэжлийн байгууллагад хүсэлтээ өгч 2023 онд хийлгэхээр тусгасан болно .

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ТАЙЛАН



2.11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Хугацаа	Тайлбар
Дархан-Уул аймгийн БОАЖГ	БОМТ-ний тайланг бичмэл болон файл хэлбэрээр хүргүүлэх	Жил бүрийн 11 сард багтаан	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийн дагуу хийж гүйцэтгэн үүгээр хүргүүлж байна.
БОАЖЯ хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлага		Жил бүрийн 12 сард багтаан	
Бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар	АМТЗ-ийн талбайд	Шалгалтаар ирсэн тухай бүрт	Тухай бүрт хянуулан шалгуулж ажилласан ба НС-ийн акт зэргийг авч ажилласан.

ДҮГНЭЛТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий “Манлай геологи хайгуул” ХХК нь 2022 онд хэрэгжүүлэхээр батлуулсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний дагуу ажиллаж дээр дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2022 оны 05 сард уурхайн нээлтийн ажил эхлэхээр байсан хэдий ч шатах тослох материал буюу шатахууны үнийн өсөлтөөр шалтгаалан төлөвлөсөн хугацаандаа гарч чадаагүй 2022 оны 08 сарын 02-ны өдөр ажлаа эхлүүлсэн.

Төслийн танилцуулга дээр дурдагдснаар 2022 онд хийх байсан олборлолтын үйл ажиллагааг явуулж чадаагүй бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж, 2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг ханган ажилласан.

2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан ч гүйцэтгэл бүрэн хийгдээгүй ажлуудыг 2023 онд нөхөн хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Цаашид шатахуун, бараа материалын үнэ тогтворжиж эдийн засгийн нөхцөл байдал хэвийн горимд орох төлөвтэй байгаа тул байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг гүйцэтгэл сайтай хийж, орон нутаг болон мэргэжлийн байгууллагуудтай нягт холбоотой хамтран ажиллах болно.

Хавсралт материалууд

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000141622



2017.04.12

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011669047

/ Хувийн хэргийн дугаар /

6172601

/ Регистрийн дугаар /

Манлай геологи хайгуул

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

1

/ дугаар /

2017.04.11

/ он, сар, өдөр /

7210

/ код /

Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

6399

4653

Геологийн суурь судалгаа хийх

Уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

10.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол, 19-р хороо, 4 хороолол, жалханц хутагт дамдинбазар, 55, 21 тоот, Утас1: 99098329,
Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газар Хуулийн этгээдийн
бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан гэмдэг
1	Дашдондов овогтой Тэгшжаргал-г Захирал-р томилсныг бүртгэв.	2017.04.12	С.Мөнхсанчир
2	Хувьцаа эзэмшигч 5 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.06.03	Э.Эрдэнэбилэг
3	Улаанбаатар, Сонгинохайрхан, 18-р хороо, 1 хороолол, 13а, 15 тоот Утас1: 88109896, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв.	2020.06.03	Э.Эрдэнэбилэг
4	Баатар овогтой Батбилэг-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2020.06.03	Э.Эрдэнэбилэг
5	Эцсийн өмчлөгч бүртгэв.	2020.06.03	Э.Эрдэнэбилэг



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцаага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



* 0 0 0 1 4 1 6 2 2 *

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ТАЙЛАН



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар *MV-021731*

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Дархан-Уул аймаг /хот/-ийн
Хонгор сум /дүүрэг/-ын
Хуурай-1 нэртэй газарт орших
31.71 гектар талбай бүхий уурхайн талбайд
хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг
зөвшөөрч улсын бүртгэлийн 9011669047 тоот гэрчилгээтэй
“Манлай геологи хайгуул” ХХК -д
энэхүү тусгай зөвшөөрлийг 2039.05.18 дуустал
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.БАТМАГНАЙ

2020 оны 10 сарын 29 өдөр

Улаанбаатар хот

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021731 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ТАЙЛАН



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
1 ДҮГЭЭР ХАВСРАГТ**

MV-021731

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
